

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

|   |                       |                     |                  |
|---|-----------------------|---------------------|------------------|
| Ярилцлага өгөгчийн нэр                              | Мишиг                 | Дугаар              | L288             |
| Оршин суугаа аймаг                                  | Хөвсгөл аймаг         | Оршин суугаа сум    | Ренчинлхүмбэ сум |
| Төрсөн газар  | Ренчинлхүмбэ сум      | Төрсөн он           |                  |
| Ажил мэргэжил                                       | Өндөр настан          |                     |                  |
| Лам байсан эсэх,<br>Шавилан сууж байсан сүм<br>хийд | Зөөлөнгийн хүрээ      | Сүм хийдийн дугаар  | ХӨРЛ 001         |
| Одоогийн сүм хийд                                   |                       | Сүм хийдийн дугаар  |                  |
| Ярилцлага авсан он сар<br>өдөр                      | 2007 оны 5-р сарын 30 | Ярилцлага авсан хүн | Д .Мөнхбат       |

### Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Зөөлөнгийн хүрээ

Мөнхбат: За манай судалгааны багийнхан өнөөдөр энэ Ренчинлхүмбэ сумын засаг даргаар 1989-1997 оны хооронд ажиллаж байсан Мишиг гуайтай уулзаад байна. Ингээд Мишиг гуай танаас дараах хэдэн зүйлийг тодруулж асуух гэсэн юм. За эхний асуулт маань энэ сумын төв дээр байж байгаа Зөөлөнгийн хүрээний туурин дээр шахуу баригдсан сүүлийн үеийн энэ шинэ дуганы талаар та товч мэдээлэл өгнө үү?

Мишиг: Ерээд оны үеэс ардчилал , зах зээл, бурхан шашин шүтлэг эрх чөлөөтэй болсон энэ цаг үеэс эхлээд одоо манай Дархад нутгийн түмэн Ренчинлхүмбэчүүд бид нар санаачилга гаргаж түүнийг сумын засаг дарга, тухайн үеийн тамгын газар дэмжиж энэ дуганы байгуулсан юм. Тэгээд энэ дуган байгуулагдсан үе бол одоогоос арван нэгэн жилийн тэртээ 1996 оны 6-р сард анхныхаа нээлтийг хийсэн юм. За энэ дуган бол яг одоо Зөөлөнгийн хүрээний туурийг сэргээж, Зөөлөнгийн хүрээний үргэлжлэл бол биш. За мөн Зөөлөнгийн хүрээг сэргээн байгуулсан явдал бас биш. Харин нутгийн олон бид бүгдийн шийдвэрээр энэ Зөөлөнгийн хүрээний туурийн баруун талыг бариулж энэ дуганыг барьсан байдаг. Энэ дуган бас баригдахдаа тухайн үед бас манай энэ Дархад нутгийн олны дунд буддын шашны зохих боловсролтой лам хуварга, санваартнууд төдийлэн их байдаггүй зэрэг учир шалтгаанаас болоод анх одоо нэрээ өгч чадаагүй юм, дугандаа. Тэгээд энэ байдал одоо өдийг хүртэл үргэлжилсээр одоо үнэндээ хэлэхэд одоо хүртэл өөрийн гэсэн нэр хаяггүй ийм дуган байгаа.

Мөнхбат: За нэгэнт одоо энэ дуган баригджээ. За тэгэхээр энэ дуганы байдлыг харахад , одоо дотоод гадаад байдлыг орж харж үзлээ, бид нар. Ингэхэд одоо ойрын үед ямар ч бурхан номын үйл ажиллагаа явуулсан байдалгүй. За тэр сахиул боллоотой нэг айл нь ямар ч цалин хөлс авдаггүй гэж байна. Тэгээд тэр айлын боллоотой барааныхаа юмыг одоо тэнд оруулаад хураагаад тавьчихсан байх юм. Энэ одоо яагаад ингээд үйл ажиллагаагаа хэвийн явуулж болоогүй юм бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мишиг: За яг ний нуугүй хэлэхэд би энэ 1996 онд төр засаг солигдоход ажлаа өгч байсан хүн.Одоо бол сумын энэ төр үахиргааны орон нутгийн ажилд бол оролцохгүй байгаа. Яг одоо ерэн зургаан оноос хойшхи манай сумын орон нутгийн удирдлагууд энэ сүмийн үйл ажиллагааг төдийлэн их дэмжээгүй, төдийлэн их дэмжээгүй. За нөгөө талаар бас нэг үйл ажиллагаа нь зогссон үндсэн шалтгаан бол манай нутгаас өөрийн гэсэн юмуу одоо, манай нутагт байнга оршин суудаг буддын шашны лам хуварга байхгүй зэрг одоо үндсэн шалтгаануудас болж энэ сүмийн үйл ажиллагаа үндсэндээ бол сүүлийн найм, есөн жил бүрэн зогссон, бүрэн зогссон. Бид эхлээд энэ сүмийг байгуулж байхдаа, энэ дуганыг байгуулж байхдааа бүр Эрдэнэтээс нутгийн харъяат хоёр ламыг авчирч, залууг авчирч тэр хоёр одоо эхний ээлжинд ээлжлээд улирлын чанартай энэ сүмийг ажиллуулж байсан, нутгийн олонд үйлчилж байсан юм аа.

Мөнхбат: За дараачийн нэг асуулт байна. Энэ ер эь ажиглаж байхад энэ сумуудаар, магадгүй аймгийн төвүүдээр бас их ховор байдаг, энэ сумын төвдөө ер нь их зохицсон есөн цагаан суварга энэ сүмээс баруун урагшаа гурван зуун метр зайд байрлаж байх юм .Ер нь өнгө үзэмжийн хувьд ч, хэлбэр хийдийн хувьд ч ер нь дажгүй хийсэн гэж хэлж болохоор ийм суварга байна. Энэ суваргын үүх түүхээс та ярьж өгөөч?

Мишиг:Энэ суварга ийм түүхтэй суварга аа. 2006 он буюу ноднин жил манай нутгийн бизнесмен ,Улаанбаатар хотод байдаг Доржжалбуу гэдэг хүн өөрийн санаачилгаар өөрөө хөрөнгө мөнгийг нь гаргаад хоёр зуун жаран сая төгрөг зарцуулж энэ есөн цагаан суваргыг босгосон юм. Гэхдээ энэ есөн цагаан суваргыг босгосоны гол зорилго нь нэгдүгээрт тэр хүн Зөөлөнгийн хүрээнд өөрийнх нь өвөг дээдэс лам хуварга байсны гэгээн дурсгалд зориулж, нөгөө талаар нутгийн олны эргэл мөргөлийн газар болгох зорилгоор энэ есөн цагаан суваргыг босгосон. За энэ есөн цагаан суваргын үрд талд одоо танар үзнэ дээ, би ч одоо юугаа мэдэхэв. Тэр Зөөлөнгийн хүрээний Төвд нэрийг Тангад үсгээр бичсэн тийм бичсэн, тийм хүрэл нэг метр гаруй диаметртэй сангийн бойпорыг байрлуулсан байгаа . Ер нь таны хэлдэг үнэн шүү, манай Хөвсгөл аймгийн бүх сүмдад төдийлэн их байдаггүй, есөн цагаан суваргыг тэгж нутгийн хүү босгосон байдаг юм.

Мөнхбат: Тэгэхээр Мишиг дарга аа, анх энэ сүм хийд байгуулагдаад хурал номоо хийдэг байсан ш дээ.Тэгэхэд ямар хурал ном хүрж байсан юм бол, тэр дуганд нь бид нар ороод харахаар дуганд бурхан номын ямар ч тийм юм байхгүй, тиймээ хуучин бурхан шүтээн байсан гэхгүй. Тэр ямар бурхан шүтээнтэй байсан юм бол?

Мишиг: Энэ анх хурал номынхоо үйл ажиллагаа эхэлж байхдаа сар бүрийн дүйчэн өдрүүдэд хурал ном хурдаг байсан юм. За энэ дуган сүмийг ашиглалтанд оруулахад манай нутгийн өндөр настан Улаанбаатар хотод амьдардаг Дашдаваа гэдэг хүн үр хүүхдийнхээ хамт энэ дуганы бурхан тахилыг бүтээлгэж ирүүлсэн байдаг.Тэгээд үйл ажиллагаа нь бүрэн зогссоноос хойш одоогоос дөрөв, таван жилийн өмнө өөрийн бүтээсэн тахил бурхнаа одоо энд байлгахгүй гээд нэгэнт одоо бид нар ном ёсоор авч чадахгүй байсан учраас тэр хүмүүс одоо ирээд аваад явсан байдаг аа.